



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Г “Ундрах дэвшилт ББСБ” ХХК-ийн  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ундрах дэвшилт ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Ундрах дэвшилт ББСБ” ХХК /Б.Ган-Эрдэнэ/-д анхааруулсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000238